



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Байгууллагад чанарын менежментийн
тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсэгт орсон албан хаагчдыг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 7 хоногийн мягмар гараг бүр өглөө 08:40 минутаас тухайн өдрийн 17:30 минутын хооронд үүрэгт ажлаас нь чөлөөлж, тухайн өдрийн ажлыг орлон гүйцэтгэх албан тушаалтанд хариуцуулан ажиллуулахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Байгууллагад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор, гэрээний хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Мягмардорж)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/118 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Д.НАРАНТУЯА

1422

01180

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 19 дугаар сарын 19-ны өдрийн 01/190 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Мягмардорж	Захиргаа, удирдлагын газрын Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Халиун	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын асуудал мэргэжилтэн
	Ч.Баяр	Эмийн бүртгэлийн хэлтсийн Үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эмийн бүртгэл, сунгалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Уранбилэг	Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газрын Вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
	С.Баасанцээ	Чанарын хяналтын газрын Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч
	Б.Баярцэцэг	Микробиологийн лабораторийн техник хариуцсан ахлах шинжээч
Нарийн бичгийн дарга:	Б.Дэнзэндуйнхэр	Захиргаа, удирдлагын газрын Маркетинг, тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн
	М.Энхжаргал	Захиргаа, удирдлагын газрын Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

--ooOOoo--